



## ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХОЛБООНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан<sup>1</sup>)

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРГЭЭ ТӨР БИЕЛҮҮЛЭЭГҮЙ ЭС ҮЙЛДЭХҮЙ НЬ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗӨРЧИЛ БОЛНО

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 1 BvR 2656/18

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2024 оны 03 сарын 24-ны өдөр

**Шийдвэрийн төлөв:** Маргаан бүхий хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн.

#### МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ” гэх) нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийн эсрэг үндэсний болон Европын Холбооны дэвшүүлсэн зорилтыг биелүүлэх хүрээнд Холбооны Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хууль (англ. Federal Climate Change Act)-ийг баталсан. Гомдол гаргагчид тус хуулийн 3 дугаар зүйлийн 3(1) дэх хэсэг<sup>2</sup>, 4 дүгээр зүйлийн 4(1) дэх хэсэг<sup>3</sup> болон Хавсралт 2-оор хүлэмжийн хий (англ. greenhouse gases) тэр дундаа нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>)-ийг бууруулахад хангалттай эрх зүйн орчныг бүрдүүлээгүй гэсэн үндэслэлээр Холбооны Үндсэн хуулийн шүүхэд ханджээ.

Тодруулбал, гомдол гаргагчид Холбооны уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хуулийн маргаан бүхий зохицуулалтад Парисын хэлэлцээр (англ. Paris Climate Agreement)-ийн дэлхийн дундаж температурыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2°C-с доош байлгах, боломжтой бол 1.5°C-ээс хэтрүүлэхгүй байх

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: [https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Entscheidungen/EN/2021/03/rs20210324\\_1bvr265618en.html](https://www.bundesverfassungsgericht.de/SharedDocs/Entscheidungen/EN/2021/03/rs20210324_1bvr265618en.html)

<sup>2</sup> “Хүлэмжийн хийн ялгарлыг 1990 оны түвшинтэй харьцуулан аажмаар бууруулна. 2030 он гэхэд бууруулах хэмжээ хамгийн багадаа 55 хувь байна” Federal Climate Change Act of Federal Republic of Germany (2019), art. 3(1).

<sup>3</sup> “Энэ хуулийн 3 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт заасан үндэсний уур амьсгалын зорилтыг биелүүлэхийн тулд дараах салбаруудад жил тутам ялгарлын хэмжээг тогтоож, бууруулах зорилтыг тодорхойлно. Үүнд: (1) Эрчим хүч, (2) Үйлдвэрлэл, (3) Тээвэр, (4) Барилга, (5) Хөдөө аж ахуй, (6) Хог хаягдал болон бусад салбар. Тус салбарын ялгарлын эх үүсвэр болон салбарын ангиллыг Хавсралт 1-т, 2030 он хүртэлх хугацааны жил тутмын ялгарлын хэмжээг Хавсралт 2-т үндэслэн тогтооно. Эрчим хүчний салбарт хүлэмжийн хий ялгарлыг тухайн жилд тогтоосон ялгарлын хэмжээнд аль болох тогтвортой бууруулах ёстой. 2031 оноос хойш жил тутмын бууруулах зорилтыг энэ зүйлийн (6) хэсэгт зааснаар батлагдсан журмын дагуу шинэчилнэ. Энэ хуульд заасан жил тутмын ялгарлын хэмжээг заавал биелүүлэх үүрэгтэй. Энэхүү хууль нь субъектив эрх буюу шүүхэд хандах эрх (англ. actionable legal positions)-ийг бий болгохгүй” Federal Climate Change Act, §4(1).



зорилгыг хангаж чадаагүй, мөн 2030 оноос хойш CO<sub>2</sub>-ийг бууруулах арга хэмжээг тусгаагүй гэсэн үндэслэлээр гомдол гаргажээ.

## ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

**ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр:** Холбооны Үндсэн хуулийн шүүх нь дараах үндэслэлээр Холбооны Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хуулийн 3(1), 4(1) дэх хэсэг болон мөн хуулийн Хавсралт 2-ыг Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн. Үүнд:

- 1) Холбооны Үндсэн хуулийн 2(2) дугаар зүйлийн эхний өгүүлбэр<sup>4</sup>-т заасан амьд явах болон бие махбодын халдашгүй байдлыг хангах төрийн үүрэг нь зөвхөн үндсэн эрхийн зөрчил гарсны дараа хэрэгждэггүй. Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах үүрэг нь ирээдүй үеийнхнийг (англ. future generations) хамгаалах үүргийг ч бий болгож болдог.<sup>5</sup> Гэхдээ **ирээдүй үеийнхэн болон хараахан төрөөгүй хүмүүс нь тодорхой үндсэн эрх эдэлдэггүй хэдий ч объектив эрх зүйн шаардлага<sup>6</sup>-ын үүднээс төр нь одоогийн хүн амыг төдийгүй, ирээдүй үеийнхнийг хамгаалах үүрэгтэй.** Мөн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах нь олон улсын оролцоо шаарддаг асуудал боловч үндсэн эрхийг хамгаалах үүргийг тус шалтгаанаар үгүйсгэх ёсгүй юм.
- 2) Холбооны Үндсэн хуулийн 20а дугаар зүйл<sup>7</sup> нь суурь шинжтэй Үндсэн хуулийн зохицуулалт юм. Иймд үндсэн эрхэд халдсан аливаа арга хэмжээ 20а дугаар зүйлд нийцсэн байх шаардлагатай. **Өөрөөр хэлбэл маргаан бүхий хуулийн зохицуулалт нь Холбооны Үндсэн хуулийн 20а дугаар зүйлийг зөрчиж байвал үндсэн хуулийн эрх зүйн үүднээс зөвтгөгдөх боломжгүй болно.**<sup>8</sup>
- 3) **Үндсэн хуулийн эрх зүйн дагуу зөвтгөгдөх нэмэлт шаардлага нь пропорциональ байх (англ. proportionality) зарчим юм.** Үндсэн эрхийг хамгаалах үүрэг нь хууль тогтоогчид 20а дугаар зүйлд заасны дагуу CO<sub>2</sub>-ын ялгаралтыг бууруулах арга хэмжээг урьдчилан төлөвлөсөн байдлаар, уур амьсгалын тогтвортой түвшинд хүрэх хүртэл зохицуулах үүргийг хүлээлгэдэг. Ингэхдээ хүний үндсэн эрх, эрх чөлөөг зохистой хэмжээнд хязгаарлах ёстой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үүргийг одоо болон ирээдүй үе хооронд тэгш бус хуваарилахгүй байх ёстой.<sup>9</sup> **Маргаан бүхий хуулийн зохицуулалтаар ирээдүйд үндсэн эрхэд хохирол учруулах эрсдэлийг хангалттай хязгаарлаагүй тул пропорциональ байх зарчимд нийцэхгүй байна.**
- 4) Тухайлбал, Холбооны Үндсэн хуулийн 14(1) дүгээр зүйл<sup>10</sup>-д заасны дагуу төр өмчлөх эрхийг хамгаалах үүрэг хүлээдэг. **ХБНГУ болон бусад улс орнуудад**

<sup>4</sup> “Хүн бүр амьд явах эрхтэй бөгөөд бие махбод халдашгүй байна” Basic Law for the Federal Republic of Germany (1949), art. 2(2).

<sup>5</sup> BVerfG, Order of the First Senate of 24 March 2021 – 1 BvR 2656/18, 146.

<sup>6</sup> “Төрийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэлээс хүн амын амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүрэг нь объектив шинжтэй” Ibid, 148.

<sup>7</sup> “Төр нь ирээдүй үеийнхний өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан, байгаль орчин, экосистем, амьтны аймгийг Үндсэн хуулийн дэг журмын хүрээнд хууль тогтоох замаар, болон гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь хууль, шударга ёсны дагуу үйл ажиллагаа явуулах замаар хамгаалах үүрэгтэй” Basic Law, §20a.

<sup>8</sup> BVerfG, Order of the First Senate of 24 March 2021 – 1 BvR 2656/18, 190.

<sup>9</sup> Ibid, 192.

<sup>10</sup> “Өмчлөх болон өв залгамжлах эрхийг баталгаатай эдэлнэ. Эдгээрийн агуулга, хязгаарлалтыг хуулиар тодорхойлно” Basic Law, §14(1).



уур амьсгалын өөрчлөлт нь хөдөө аж ахуйн газар, үл хөдлөх хөрөнгө зэрэг өмчид олон хэлбэрээр хохирол учруулах боломжтой тул Холбооны Үндсэн хуулийн 14(1) дүгээр зүйлийн дагуу өмчлөх эрх нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг өмчийг хамгаалах төрийн үүргийг багтаадаг.<sup>11</sup> Маргаан бүхий хуулийн зохицуулалтаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах арга хэмжээг хангалттай зохицуулаагүйн улмаас үер, далайн түвшин нэмэгдэх зэрэг эрсдэл үүсэж, энэ нь иргэдийн өмчлөх эрхийг зөрчих эрсдэлтэй юм.

Дээрх үндэслэлээр Холбооны Үндсэн хуулийн шүүх Холбооны Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хуулийн 3(1), 4(1) дэх хэсэг болон мөн хуулийн Хавсралт 2-ыг Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн байна.

---o0o---

---

<sup>11</sup> BVerfG, Order of the First Senate of 24 March 2021 – 1 BvR 2656/18, 243.